

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр
МРЦМ/202008572

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Цэцэг мандал (MV-020945) ордод геологи хайгуулын ажил гүйцэтгэж үр дүнгээр нөөцийн тодотгол тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-020945 тоот “Цагаан галт” талбайн Цэцэг мандал ордод геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан бичиж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харьяа Шижир Алт алтны үйлдвэрийн алт олборлолтыг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2018, 2019 оны санхүүгийн тайлан ирүүлэх/,
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 11 дүгээр сарын 05–ны өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2020 оны 11 дүгээр сарын 9–ний өдрийн 14 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.
5. Тендерийг 2020 оны 11 дүгээр сарын 9–ний өдрийн 14.10 цагт цахимаар нээнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 504 тоот,

И-мейл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-158